



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 11/к

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх "Дашгэмцэллин хийдийн халаалтын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Мөнхцоож - Сайнцагаан сум ЗДТГ-ын
ХТГ-ын дарга

Гишүүд: Ц.Эрдэнээ - Иргэний төлөөлөл
И.Нямдаваа - Дэрэн сум ЗДОрлогч
С.Наранчимэг - Сайнцагаан сум ЗДТГ-ын
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн - ОНӨГ-ын ХАА
хариуцсан ахлах мэргэжилтэн

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Д.Мөнхцоож/-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Адъяасүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200030